



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот


Г Журам, жагсаалт батлах тухай Г

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 2 дах заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолын 3.1.7 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1 “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-ыг нэгдүгээр, “Хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”, “Ажил, мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн хуудас”, “Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хуудас”-ыг гуравдугаар, “Эрүүл мэндийн үзлэгийн нэгдсэн тайлан”, “Эрүүл мэндийн үзлэгийн тайланд хавсаргах баримт бичгийн жагсаалт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2 Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт даалгасугай.

3 Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/206 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 10 дугаар сарын 20 өдрийн
340 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь ажилтанд эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад ажил олгогч, ажилтан, эмнэлгийн байгууллагын үүрэг, тайлан гаргах, хянах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэг нь урьдчилсан ба хугацаат гэсэн 2 төрөлтэй байна.
- 1.3 Эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгийг хүн амд 7-гоос доошгүй чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн байгууллага зохион байгуулна.
- 1.4 Эрүүл мэндийн хугацаат үзлэгийг мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач эмчээр ахалсан төрөлжсөн мэргэжлийн эмч нарын баг зохион байгуулна. Багийн бүрэлдэхүүнийг эмнэлгийн байгууллагын даргын тушаалаар батална.
- 1.5 Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн эмч нарын багт зүрх судас, дотор, мэдрэл, арьс, харшил, хордлого, нүд, чих, хамар, хоолой, мэс засалын эмч нар байна.
- 1.6 Энэ журмыг Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллага, хуульд өөрөөр заагаагүй бол нэгэн адил мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг гэж шинээр ажилд орох ажилтны эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээ, мэргэжлийн тохироог;
- 2.2 Эрүүл мэндийн хугацаат үзлэг гэж ажилтны хөдөлмөрлөх явцад хийх эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээ, ажил мэргэжлийн тохироог;
- 2.3 Мэргэжлийн тохироо гэж ажилтны эрүүл мэнд тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд тохирох эсэхийг эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээгээр тодорхойлохыг хэлнэ.

Гурав. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг

- 3.1 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг нь ажилтан тухайн ажлыг гүйцэтгэхэд эрүүл мэндээр тохирох эсэхийг тодорхойлно.
- 3.2 Ажил олгогч эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт орох ажилтанд энэ журмын 3 дугаар хавсралтаар баталсан үзлэгийн хуудсыг олгож, үзлэгт илгээнэ.
- 3.3 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх эмнэлгийн байгууллага энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан жагсаалтын дагуу ажилтанд үзлэг, шинжилгээ хийж, ажилтны эрүүл мэнд, мэргэжлийн тохирооны дүгнэлт гаргана.
- 3.4 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгээр ажилтны уг мэргэжилд тохирох эсэхийг шийдвэрлээгүй бол мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.

Дөрөв. Эрүүл мэндийн хугацаат үзлэг


- 4.1 Эрүүл мэндийн хугацаат үзлэг нь ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед нь илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой.
- 4.2 Ажил олгогч эрүүл мэндийн үзлэгт орох ажилтанд энэ журмын 3 дугаар хавсралтаар баталсан үзлэгийн хуудсыг өгч үзлэгт илгээнэ.
- 4.3 Эрүүл мэндийн хугацаат үзлэгийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан давтамжийн дагуу хийнэ.
- 4.4 Энэ журамын хавсралтад ороогүй ажил, мэргэжлийн эрүүл мэндийн үзлэгийг 2 жил тутамд хийнэ.

Тав. Ажилтны үүрэг

- 5.1 Ажилтан урьдчилсан ба хугацаат үзлэгт ажил олгогчоос тогтоосон хугацаанд орно.
- 5.2 Иргэний эрүүл мэндийн хяналтын картыг хөтлөх, өвчлөлд хүргэдэг зан үйл, эрсдэлт хүчин зүйлсээс татгалзах, эмчийн зөвлөмжийг хэрэгжүүлж өөрийн эрүүл мэндийг хамгаална.
- 5.3 Эрүүл мэндийн үзлэгээс гарсан мэргэжлийн тохирооны дагуу ажил хөдөлмөр эрхэлнэ.

Зургаа. Ажил олгогчийн үүрэг

- 6.1 Ажил олгогч шинэ ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн дүгнэлтийг үндэслэн тохирсон ажилд авна. Үзлэгийн дүгнэлтийг ажилтны хувийн хэрэгт хавсарган хадгална.



- 6.2 Ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг хүний нөөцийн ажилтан зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, эрүүл мэнд хариуцсан ажилтан дотоодын хяналтыг тавина.
- 6.3 Эрүүл мэндийн байгууллагатай ажиллагсдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг хийлгэх гэрээ байгуулна. Үзлэгийн хуваарийг тухайн оны 1 дүгээр сард багтаан эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ.
- 6.4 Хөдөлмөрийн нөхцөлийн танилцуулга, үзлэгт хамрагдах ажиллагсдын нэрсийн жагсаалтыг албан тушаалын хамт гаргаж үзлэг эхлэхээс 30 хоногийн өмнө өгч үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.
- 6.5 Эрүүл мэндийн үзлэгт орох хуудсаар хангаж, ажилтны үзлэгийн хуудсыг хувийн хэрэгт хавсарган хадгалж, байгууллагад мэдээний нэгдсэн сан байгуулан хяналтанд авна.
- 6.6 Ажилтны эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хуулийн хүрээнд хадгална.
- 6.7 Эмнэлгийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангана.
- 6.8 Эрүүл мэндийн хугацаат үзлэгийн хуудсыг байгууллагын архивт хадгалж, хуулбарыг ажилтанд олгоно.


Долоо. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- 7.1 Ажил олгогчтой эрүүл мэндийн хугацаат үзлэг хийх, хамтран ажиллах гэрээ байгуулна.
- 7.2 Эрүүл мэндийн хугацаат үзлэгт орох ажиллагсдын нэрсийг ажил олгогчоос ирүүлснээс хойш 30 хоногийн дотор үзлэгийн хуваарийг ажил олгогчтой зөвшилцөж батална.
- 7.3 Үзлэгт хамрагдах ажиллагсдын нэрсийн жагсаалт, хөдөлмөрийн нөхцлийг үндэслэн үзлэг хийх эмч, мэргэжилтэн, оношзүйн болон лабораторийн шинжилгээний төрөл, хэмжээг тодорхойлж бэлтгэлийг хангана.
- 7.4 Ажилтан тус бүрт эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээ хийж эрүүл мэндийн дүгнэлт, зөвлөмж гаргана.
- 7.5 Эрүүл мэндийн үзлэгээр ажилтанд ердийн өвчний шалтгаанаар хөдөлмөр зохицуулалт хийх шаардлагатай бол ажилтны харъяа эмнэлгийн байгууллагын Эмчилгээ хяналтын комиссоор шийдвэрлэнэ.

7.6 Эрүүл мэндийн хугацаат үзлэг дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор эрүүл мэндийн үзлэгийн тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтаар баталсан загварын дагуу нэгтгэн гаргана.

7.7 Нэгдсэн тайланг ажил олгогч болон мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагад ажлын 10 хоногийн дотор хүргүүлнэ.

**Найм. Мэргэжлээс шалтгаалсан өвчний асуудал эрхэлсэн
мэргэжлийн байгууллага**



8.1 Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлэх эрүүл мэндийн хугацаат үзлэгийг хөдөлмөрийн газрын дор, хортой, хүнд, халуун нөхцөлийн ажилтнуудад 2 жил тутам хийж гүйцэтгэнэ.

8.2 Ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчний онош тогтоох, урьдчилсан оношийг баталгаажуулах, мэргэжлийн тохироо тодорхойлох үзлэг шинжилгээ хийнэ.

8.3 Эрүүл мэндийн хугацаат үзлэг хийсэн эмнэлгүүдээс ирүүлсэн нэгдсэн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор Статистикийн үндэсний газар, Эрүүл мэндийн болон Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хяналтын байгууллагад тус тус хүргүүлнэ.

8.4 Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэг, мэргэжлийн тохироо, мэргэжлээс шалтгаалсан өвчин, ажлын байрны эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн судалгаа тандалт хийх, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа болон хамтарсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулна.

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 10 дугаар сарын 20 өдрийн
340 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Хөдөлмөрийн нөхцөлөөс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт

№	Химийн бодисууд	Олон улсын CAS дугаар	Үзлэгийн хугацаа	Эмнэлгийн өвөрмөц нэмэлт шинжилгээнүүд
1.	Ацетальдегид /Acetaldehyde/	00075-07-0	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Шээс, амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
2.	Ацетон /Acetone/	00067-64-1	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Нөлөөллийн үед бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
3.	Ацетонитрил /Acetonitrile/	00075-05-8	жилд 2 удаа	Цусанд сүүний хүчилийн pH үзэх Цусанд цианид, бикарбонат үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
4.	Ацетиламинофлуорен, 2- /Acetylaminofluorene, 2-/	00053-96-3	жилд 2 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
5.	Ацетилен тетрабромид /Acetylene tetrabromide/	00079-27-6	жилд 2 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны шинжилгээ
6.	Акролин /Acrolein/	00107-02-8	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ: уушгины хүчилсэн амьдралын багтаамж (УХАБ), огцом амьсгал гаргалтын эзэлхүүн эхний секунд (ОГАЭ 1с) үзэх Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
7.	Акриламид /Acrylamide/	00079-06-1	жилд 1 удаа	Мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг (электромиографи) Улаан эсийн тоо

8.	Акрилнитрил /Acrylonitrile/	00107-13-1	жилд 1 удаа	Цээжний рентген зураг 40-с дээш насны ажилчдад өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээ хийх Цусанд сүүний хүчилийн рН, цианид, бикарбонат үзэх Цусны ийлдсийн шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит Спирометрийн шинжилгээ Улаан эсийн тоо Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
9.	Альдрин /Aldrin/	00309-00-2	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Ретикулоцит тоолох Шээсний шинжилгээ
10.	Аллилхлорид /Allyl chloride/	00107-05-1	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) үзэх Шээсний шинжилгээ
11.	Хөнгөн цагаан металл/нунтаг /Aluminum metal (powder)/	07429-90-5	жилд 1 удаа	Цусны ийлдсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цээжний рентген зураг Цэрний эсийн шинжилгээ Туберкулины арьсны сорил Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
12.	Аминодифенил, 4 /Aminodiphenyl, 4-/	00092-67-1	жилд 1 удаа	Цистоскопи Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
13.	Аммиак /Ammonia/	07664-41-7	жилд 2 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) үзэх Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ

14.	Анилин /Aniline/	00062-53-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусанд гемоглобин, метгемоглобин, карбоксигемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Улаан эсийн тоо Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд эсийн шинжилгээ (цитологи), гематури илрүүлэх
15.	Анизидин (о, р-изомерүүд) /Anisidine (o-,p-isomers)/	Олон дугаартай	жилд 1 удаа	Цусанд метгемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Ретикулоцит тоолох Шээсний шинжилгээ
16.	Сурьма, түүний нэгдэлүүд /Antimony and compounds/	Олон дугаартай	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
17.	Хүнцэл, органик биш, нэгдлүүд /Arsenic, inorganic compounds/	Олон дугаартай	жилд 2 удаа	Цээжний рентген зураг Хамрын үзлэг Арьсны үзлэг Үсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Мэдрэлийн дамжуулалт үзэх шинжилгээ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
18.	Арсин /Arsine/	07784-42-1	жилд 2 удаа	Цусны гемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Цусанд ретикулоцит тоолох Шээсэнд гемоглобин Шээсний шинжилгээ Цагаан эсийн шинжилгээ
19.	Асбест /Asbestos/	Олон дугаартай	жилд 1 удаа	Цээжний рентген шинжилгээ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) үзэх Рентген шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Туберкулины арьсны сорил
20.	Азинфосметил /Azinphos-methyl (Guthion®)/	00086-50-0	жилд 1 удаа	Цусны ийлдсийн шинжилгээ Холинэстераза (Цусны ийлдсийн шинжилгээ, улаан эсийн) шинжлэх Холинэстераза (улаан эсийн) шинжлэх
21.	Бари, түүний нэгдэлүүд /Barium and compounds/	Олон дугаартай	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

22.	Беномил /Benomyf/	17804-35-2	жилд 1 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
23.	Бензол /Benzene/	00071-43-2	жилд 2 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (улаан эс, цагаан эс, ялтас эс, гематокрит, гемоглобин) Спирометрийн шинжилгээ Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цагаан эсийн шинжилгээ
24.	Бензидин /Benzidine/	00092-87-5	жилд 2 удаа	Цистоскопи Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээнд эсийн, гематури илрүүлэх
25.	Бензилхлорид /Benzyl chloride/	00100-44-7	жилд 2 удаа	Цээжний рентген зураг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ
26.	Биндэр, түүний нэгдэлүүд /Beryllium and compounds/	Олон дугаартай	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Эдийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цагаан эсийн шинжилгээ Лимфоцитын трансформацийн урвал
27.	Бис-хлорметилийн эфир /Bischloromethylether/	00542-88-1	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи)
28.	3 фторт бор /Boron trifluoride/	07637-07-2	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цагаан эсийн шинжилгээ
29.	Бром /Bromine/	07726-95-6	жилд 2 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
30.	1,3-бутадиен /Butadiene-1,3/	00106-99-0	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Улаан эсийн тоо Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

31.	2-бутокси этилийн спирт/Butoxyethanol, 2-/	00111-76-2	жилд 1 удаа	Цусны гемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Улаан эсийн хэврэг чанар шинжлэх Цагаан эсийн шинжилгээ
32.	n-бутилийн спирт /Butyl alcohol, n-/	00071-36-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
33.	Терт бутил хромат /Butyl chromate, tert-/	01189-85-1	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
34.	Бутилглицидилийн эфир /Butyl glycidyl ether, - (BGE)/	02426-08-6	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ
35.	n-бутилмеркаптан /Butyl mercaptan, n-/	00109-79-5	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
36.	p-терт-бутилтолуол /Butyltoluene, p-tert-/	00098-51-1	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
37.	Кадьми (тоос, утаа) /Cadmium dust and fume/	Олон дугаартай	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд β- микроглобулин үзэх Цусны хийн шинжилгээ Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Элэгний үйл ажиллагааны шинжилгээ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ Шээсний эсийн шинжилгээ
38.	Нийлэг камфор /Camphor, synthetic/	00076-22-2	жилд 1 удаа	Цусанд мочецин, кальци, нүүрсхүчлийн хий, глюкоз шинжлэх Цусны сийвэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
39.	Карбарил /Carbaryl (Sevin®)/	00063-25-2	жилд 1 удаа	Цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Холинэстераза үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
40.	Хөө /Carbon black/	01333-86-4	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ

41.	Хүхэрт нүүрстөрөгч/Carbon disulfide/	00075-15-0	жилд 1 удаа	Мочевин үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Нүдний үзлэг Зүрхний цахилгаан бичлэг Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний тунадас шинжлэх
42.	Нүүрстөрөгчийн дутуу исэл (угаарын хий) /Carbon monoxide/	00630-08-0	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусанд карбоксигемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
43.	4 хлорт нүүрстөрөгч /Carbon tetrachloride/	00056-23-5	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Бөөрний үйл ажиллагааны шинжилгээ элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
44.	Хлордан /Chlordane/	00057-74-9	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусанд мочевин, кальци, нүүрсхүчлийн хий, глюкоз үзэх Эдийн шинжилгээ Шээсний шинжилгээ
45.	Хлоржуулсан дифенилийн исэл /Chlorinated diphenyl oxide/	55720-99-5	жилд 1 удаа	Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ
46.	Хлор /Chlorine/	07782-50-5	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
47.	Хлорын давхар исэл /Chlorine dioxide/	10049-04-4	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
48.	3 фторт хлор /Chlorine trifluoride/	07790-91-2	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ

49.	Хлорт бензол /Chlorobenzene/	00108-90-7	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Ажлын 7 хоногийн төгсгөлд шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
50.	Хлороформ (Трихлорметан) /Chloroform (Trichloromethane)/	00067-66-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсний шинжилгээ
51.	Хлорметил-метилийн эфир /Chloromethyl methyl ether/	00107-30-2	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи)
52.	Хлорпикрин /Chloropicrin/	00076-06-2	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
53.	Бета-хлоропрен /Chloroprene, beta-/	00126-99-8	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ
54.	Хромын хүчил ба хроматууд /Chromic acid and chromates/	Олон дугаартай	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ Цагаан эсийн шинжилгээ
55.	Хром (металл ба нэгдэлүүд) /Chromium, metal and compounds/	Олон дугаартай	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн/бодисын солилцооны метаболит үзэх Эдийн шинжилгээ Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ Цусны улаан эсийн тоо үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
56.	Нүүрсний тоос /Coal dust/	68131-74-8	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Рентген шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Туберкулины арьсны сорил
57.	Нүүрсний ууршимтгай, давирхай /Coal tar pitch volatiles/	65996-93-2	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Фотопатч тест Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд гематури илрүүлэх, эсийн

				шинжилгээ хийх
58.	Кобальт (металл, тоос, утаа) /Cobalt metal, dust, and fume/	07440-48-4	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээт химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
59.	Коксын зуухны хаягдал /Coke oven emissions/	—	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Арьсны үзлэг Шээсний эсийн шинжилгээ (цитологи) Шээсэнд глюкоз, альбумин, гематури илрүүлэх Цистоскопи Цэрний эсийн шинжилгээ Шээсний шинжилгээ
60.	Зэс (тоос, манан) /Copper dust and mist/	07440-50-8	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээ Эдийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
61.	Хөвөн даавууны тоос /Cotton dust/	—	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цээжний рентген шинжилгээ Спирометрийн шинжилгээ үзэх
62.	п-крезол /Cresol, p-/	00106-44-5	жилд 1 удаа	Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Ээлжинд гарахын өмнө болон дараа шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
63.	Кумол /Cumene/	00098-82-8	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
64.	Цианид /Cyanide/	00057-12-5	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Бүхэл цусанд сүүний хүчлийн рН (lac рН) үзэх Цусанд цианид үзэх Цусны сийвэнд бикарбонат үзэх Цээжний рентген шинжилгээ Спирометрийн шинжилгээ үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
65.	Циклогексан /Cyclohexane/	00110-82-7	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

66.	Циклогексанон /Cyclohexanone/	00108-94-1	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
67.	Деметон /Demeton (Systox®)/	08065-48-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд болинэстераза үзэх Холинэстераза үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
68.	Диацетоны спирт /Diacetone alcohol/	00123-42-2	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ үзэх
69.	Диазометан /Diazomethane/	00334-88-3	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
70.	Диборан /Diborane/	19287-45-7	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
71.	1,2-дибром-3-хлорпропан (ДБХП) /Dibromo-3-chloropropane, 1,2-(DBCP)/	00096-12-8	жилд 1 удаа	Цусанд ФСГ, ЛГ, нийт эстроген (эм) Тестостерон шинжлэх Шээс бэлгийн зам (төмсөгний хэмжээ, эр бэлгийн эс тоолох) Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Бамбайн үйл ажиллагааны шинжилгээ Шээсний шинжилгээ
72.	о-дихлорбензол/Dichlorobenzene, o-/	00095-50-1	жилд 2 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
73.	п-дихлорбензол /Dichlorobenzene, p-/	00106-46-7	жилд 2 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
74.	3,3 - дихлорбензидин/Dichlorobenzidine, 3,3'-/	00091-94-1	жилд 2 удаа	Спирометрийн шинжилгээ
75.	Дихлордифенил трихлорэтан /Dichlorodiphenyltrichloroethane (DDT)/	00050-29-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээт химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
76.	2,4-дихлорфеноксицууны хүчил(2,4-Д) /Dichlorophenoxyacetic acid, 2,4- (2,4-D)/	00094-75-7	жилд 1 удаа	Цусны сийвэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
77.	Дихлорэтилийн эфир /Dichloroethyl ether/	00111-44-4	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг

78.	Дихлорвинил(диметилфосфат) /Dichlorvos (DDVP)/	00062-73-7	жилд 1 удаа	Бүхэл цусанд холинэстераза үзэх Холинэстераза үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
79.	Дельдрин /Dieldrin/	00060-57-1	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээ Эдийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
80.	Диглицилийн эфир /Diglycidyl ether (DGE)/	02238-07-5	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
81.	Диизобутилкетон /Diisobutyl ketone/	00108-83-8	жилд 2 удаа	Спирометрийн шинжилгээ
82.	Диметил цуу хүчлийн амид /Dimethyl acetamide/	00127-19-5	жилд 1 удаа	Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
83.	Диметилсульфат /Dimethyl sulfate/	00077-78-1	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ, мочевин үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ Шээсний шинжилгээ (шээсэнд тунадас шинжлэх) Цагаан эсийн шинжилгээ
84.	4-Диметиламиноазобензол, /Dimethylaminoazobenzene, 4-/	00060-11-7	жилд 2 удаа	
85.	Диметиланилин (N, N-диметиланилин) /Dimethylaniline (N,N-Dimethylaniline)/	00121-69-7	жилд 1 удаа	Бүхэл цусанд метгемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
86.	1,2-диметил2,2-дибромдихлорэтилфосфат /Dimethyl-1,2-dibromo-2,2-dichloroethyl phosphate (Naled)/	00300-76-5	жилд 1 удаа	Бүхэл цусанд холинэстераза үзэх
87.	Диметилформаид (DMF) /Dimethylformamide (DMF)/	00068-12-2	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

88.	1,1- диметилгидразин/Dimethylhydrazine, 1,1-/	00057-14-7	жилд 1 удаа	Бүхэл цусанд мочецин, кальци, нүүрсхүчлийн хий, глюкоз үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
89.	Динитробензол (бүх изомерүүд) /Dinitrobenzene (all isomers)/	Олон дугаартай	жилд 2 удаа	Бүхэл цусанд метгемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Ээлжээс буух үед бүхэл цусанд метгемоглобин үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ
90.	О-динитрокрезол /Dinitro-o-cresol/	00534-52-1	7 хоног	7 хоног бүр цусны шинжилгээ
91.	2,4-динитротолуол /Dinitrotoluene, 2,4-/	00121-14-2	жилд 1 удаа	Бүхэл цусанд метгемоглобин үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
92.	Диэтилен, Диоксан Диэтилен диоксид /Diethylene, Dioxane Diethylene dioxide/	00123-91-1	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны сийвэнд мочецин үзэх Цээжний рентген зураг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Бөөрний үйл ажиллагаа үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх шээсний тунадасын шинжилгээ Шээсний шинжилгээ Ээлжээс буух үед шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
93.	Дифенил (Бифенил) /Diphenyl (Biphenyl)/	00092-52-4	жилд 1 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
94.	Эндрин /Endrin/	00072-20-8	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны сийвэн, ийлдсийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
95.	Эпихлоргидрин /Epichlorohydrin/	00106-89-8	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Шээсний шинжилгээ
96.	Этил-п-нитрофенол /Ethyl p-nitrophenol/	02104-64-5	жилд 1 удаа	Холинэстераза үзэх
97.	Этоксизтанол, 2- этилцеллоз/Ethoxyethanol, 2- (ethyl cellosolve)/	00110-80-5	жилд 1 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

98.	Этилийн спирт (этанол) /Ethyl alcohol (Ethanol)/	00064-17-5	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
99.	Этилбензол /Ethyl benzene/	00100-41-4	жилд 2 удаа	Нөлөөллийн үед бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
100.	Этилийн эфир (эфир) /Ethyl ether (Ether)/	00060-29-7	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
101.	Этилмеркаптан /Ethyl mercaptan/	00075-08-1	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ Цэрний эсийн шинжилгээ (цитологи) Цагаан эсийн шинжилгээ
102.	Этиленхлоргидрин /Ethylene chlorohydrin/	00107-07-3	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсний шинжилгээ
103.	Этилендибромид /Ethylene dibromide/	00106-93-4	жилд 2 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ, мочефин Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний тунадасын шинжилгээ
104.	Этилендихлорид /Ethylene dichloride/	00107-06-2	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ
105.	Этиленгликоль динитрат /Ethylene glycol dinitrate/	00628-96-6	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Нөлөөллийн үед бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

106.	Эпоксид /Ethylene oxide/	00075-21-8	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (цагаан эс томьёо, улаан эс, гематокрит, гемоглобин) Цусны хийн шинжилгээ Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ
107.	Этиленимин /Ethyleneimine/	00151-56-4	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ Цагаан эсийн эгнээ тоолох
108.	Төмөр, ванадийн тоос /Ferrovanadium dust/	12604-58-9	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ
109.	Фторид, органик биш /Fluoride, inorganic/	16984-48-8	жилд 1 удаа	Цусны сийвэн Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Бага аарцгийн рентген зураг Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
110.	Фтор /Fluorine/	07782-41-4	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ Цагаан эсийн эгнээ тоолох
111.	Формальдегид /Formaldehyde/	00050-00-0	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (ээлжинд гарахын өмнө болон дараа) Фотопатч тест РрТ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
112.	Фурфурол /Furfural/	00098-01-1	жилд 1 удаа	Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
113.	Фурфурилийн спирт /Furfuryl alcohol/	00098-00-0	жилд 1 удаа	Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
114.	Байгалийн графит/Graphite, natural/	07782-42-5	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)

115.	Гексахлорнафтален (Halowax 1014) /Hexachloronaphthalene (Halowax 1014)/	01335-87-1	жилд 1 удаа	Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ
116.	n-гексан /Hexane, n-/	00110-54-3	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг (электромиографи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
117.	Гидразин /Hydrazine/	00302-01-2	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
118.	Хлорт устөрөгч (Давсны хүчил) /Hydrogen chloride (Hydrochloric acid)/	07647-01-0	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
119.	Устөрөгчийн цианид (Синилийн хүчил) /Hydrogen cyanide (Hydrocyanic acid)/	00074-90-8	жилд 1 удаа	Цусанд сүүний хүчлийн рН шинжлэх (Lac рН) Цусанд карбоксигемоглобин, бикарбонат (СОНb) ЗЦБ Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх
120.	Фторт устөрөгч (Фторын хүчил) /Hydrogen fluoride (Hydrofluoric acid)/	07664-39-3	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг Зүрхний цахилгаан бичлэг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Бага аарцгийн рентген зураг Цэрний эсийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх ээлжинд гарахын өмнө болон дараа Шээсний шинжилгээ Цагаан эсийн шинжилгээ
121.	Хүхэрт устөрөгч /Hydrogen sulfide/	07783-06-4	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусанд карбоксигемоглобин (СОНb) Цусны сийвэн Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
122.	Гидрохинон /Hydroquinone/	00123-31-9	жилд 1 удаа	Нүдний үзлэг Спирометрийн шинжилгээ
123.	Иод /Iodine/	07553-56-2	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с)
124.	Төмрийн ислийн утаа /Iron oxide fume/	01309-37-1	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
125.	Изофорон /Isophorone/	00078-59-1	жилд 1 удаа	Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ
126.	Изопропилийн спирт (изопропанол) /Isopropyl alcohol	00067-63-0	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн

	(Isopropanol)/			нэгдэл/метаболит үзэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
127.	Изопропил глицидилийн эфир /Isopropyl glycidyl ether (IGE)/	04016-14-2	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ
128.	Кетэн /Ketene/	00463-51-4	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Цээжний рентген зураг ЗЦБ Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Цэрний эсийн шинжилгээ Цагаан эсийн шинжилгээ
129.	Хар тугалга, органик биш /Lead, inorganic/	07439-92-1	жилд 2 удаа	Цусанд (хар тугалга, гемоглобин, гематокрит, цайр протопорфирин, мочевин, креатинин) үзэх Артерийн даралт Шээсний микроскопийн шинжилгээ Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Мэдрэлийн дамжуулалт үзэх шинжилгээ Мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг (электромиографи) Улаан эс шинжлэх Улаан эсийн цайр протопорфирин шинжлэх Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цусанд цайр протопорфирин
130.	Линдан /Lindane/	00058-89-9	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээ Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
131.	Литийн гидрид /Lithium hydride/	07580-67-8	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны ийлдсийн шинжилгээ Эдийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
132.	Магнийн ислийн манан /Magnesium oxide fume/	01309-48-4	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх
133.	Малатин /Malathion/	00121-75-5	жилд 1 удаа	Цусны ийлдсийн шинжилгээ Бүхэл цусанд холинэстераза үзэх Холинэстераза үзэх Цээжний рентген зураг Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
134.	Малеины ангидрид /Maleic anhydride/	00108-31-6	жилд 1 удаа	Цусны хийн шинжилгээ Зүрхний цахилгаан бичлэг Цэрний эсийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Цагаан эсийн шинжилгээ

135.	Манган түүний нэгдэлүүд /Manganese and compounds/	Олон дугаартай	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Цээжний рентген зураг Спирометрийн шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
136.	Мөнгөн ус, түүний органик бишнэгдэлүүд /Mercury and inorganic compounds/	Олон дугаартай	жилд 2 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Эдийн шинжилгээ Цусанд мочевин үзэх Мэдрэлийн дамжуулалт үзэх шинжилгээ Мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг (электромиографи) Бамбайн үйл ажиллагааны шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх (дараагийн ээлжинд гарахын өмнө, ээлжийн урд) Шээсэнд тунадас шинжлэх Шээсний шинжилгээ
137.	Мөнгөн ус, алкилорганик нэгдэлүүд /Mercury, organo alkyl compounds/	Олон дугаартай	жилд 1 удаа	Үсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг (электромиографи) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Шээсний шинжилгээ
138.	2-метокси этилийн спирт(метилцеллоз) /Methoxyethanol, 2-(Methyl cellosolve)/	00109-86-4	жилд 1 удаа	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх
139.	Метилийн спирт (метанол) /Methyl alcohol (Methanol)/	00067-56-1	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цусны pH үзэх Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх (ээлжинд гарахын өмнө болон дараа) Цусанд бикарбонат шинжлэх Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Элэгний үйл ажиллагааны дэлгэрэнгүй шинжилгээ Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх Холинэстераза үзэх
140.	Метил n-амилкетон /Methyl n-amyl ketone/	00110-43-0	жилд 1 удаа	Спирометрийн шинжилгээ
141.	Метилбромид /Methyl bromide/	00074-83-9	жилд 1 удаа	Бүхэл цусанд химийн нэгдэл/метаболит үзэх Цээжний рентген зураг Амьсгалаар гадагшилсан агаарт химийн нэгдэл/метаболит үзэх Спирометрийн шинжилгээ (УХАБ, ОАГЭ1с) Шээсэнд химийн нэгдэл/метаболит үзэх

